

БИЗНЕСИЙН НИЙГМИЙН ХАРИУЦЛАГА БА ЁС ЗҮЙ

Хүрэх үр дүн:

- Бизнесийн ёс зүйн талаар мэддэгтэй болох;
- Бизнесийн үйл ажиллагаатай холбоотой ёс зүйн асуудлыг тодорхойлож сурах;
- Бизнесийн байгууллага үйл ажиллагаандаа ёс зүйг баримталж буй эсэхийг тодорхойлж сурах;
- Нийгмийн хариуцлага ба бизнесийн үйл ажиллагааны хоорондын холбоог ойлгох;
- Бизнесийн ёс зүйг баримтлан үйл ажиллагаа явуулах нь ямар ач холбогдолтой болохыг ойлгож мэднэ;


Агуулгын хувьд:

Бизнесийн ёс зүйтэй үйл ажиллагааны үр дүнд бизнесийн байгууллага зах зээлд тогтвортой оршин тогтоно. Зах зээлд байр сууриа тогтвортой хадгалах, орлого ашгаа нэмэгдүүлэх нь бизнесийн байгууллагын үндсэн зорилго юм. Гэхдээ орлого ашгаа нэмэгдүүлэхийн зэрэгцээ бизнесийн үйл ажиллагааг нийгэмд тод, нээлттэй, нийгэм, байгаль орчинд ээлтэй явуулах хэрэгтэй.

Энэ сэдвийн хүрээнд байгууллагын нийгмийн хариуцлага, түүний төрөл, байгууллагын ёс зүйг олон талаас нь ярилцаж, өөрийн гэсэн ойлголттой болоход туслана. Ахлах ангийн сурагчдын хувьд өдөр тутам санхүүгийн харилцаанд орж байхдаа үйлчилгээний байгууллагын нийгмийн хариуцлага, түүний төрөл, ёс зүйн талаар зөв, бурууг тодорхойлоход нь анхаарлыг хандуулж чиглүүлэх нь зүйтэй.

Тэр болгон нийгмийн хариуцлагын төрлийг сурагч бие даан ялгаж чадахгүй. Тиймээс үйл ажиллагааны олон төрлөөс хамааран орлого олж байгаа арга зам нь ёс зүйтэй, хүн, нийгэм, байгаль орчинд ээлтэй байна гэдгийг тодорхойлох ёстойг ойлгуулах нь зүйтэй. Жишээ нь, газрын тос хайгуулын үйл ажиллагаа эрхэлдэг бол өрөмдлөгөө хийсэн газарт нөхөн сэргээлтийг заавал хийдэг байх, газрын тосноос гарсан шаарыг хадгалж байсан цооногт нутгийнхан орж гэмтэхгүй байх хамгаалалтыг сайн хийх, олборлосон газрын тоосоо зарж борлуулсан бол шударгаар татвараа төлдөг байх зэрэг нийгмийн хариуцлагуудын олон төрөл байгааг ялгахад нь туслах нь зүйтэй.

Зах зээлд үйл ажиллагаа явуулж байгаа байгууллагуудын ашиг сонирхол, үнэт зүйл, дотоод үйл ажиллагааны зарчим нь ялгаатай. Бизнесийн байгууллагын шийдвэрлэвэл зохих нийгмийн асуудал нь бизнесийн үйл ажиллагаанаас үүдэн ялгаатай байна. Мөн бизнесийн ёс зүй дараах 3 хүчин зүйлээс хамаардаг тул ёс зүйг тэнцвэртэй байлгах зохицуулалт бизнест өдөр тутам тулгардаг болохыг мэдүүлэх нь чухал юм.



Нийгмийн хариуцлага өргөн хүрээтэй, хийсвэр зүйл байдаг. Нийгмийн хариуцлагын талаар сурагчдад тайлбарлаж түүнийг биелүүлээгүйгээс үүсэх сөрөг үр дагаврыг онцлоорой. Бизнесийн байгууллагын үйл ажиллагааны явцад хэрэгжүүлэх нийгмийн хариуцлага нь түүний үйл ажиллагаанаас үүдэлтэй. Харин, бизнес өргөжин тэлээгүй байхад ч байдаг нийгмийн хариуцлага нь нийгмийн хөгжлөөс үүдэлтэй. Үүнтэй холбоотой бий болох асуудлыг шийдвэрлэхдээ юунаас үүсэн бий болсон? Хэрхэн асуудлыг шийдвэрлэх вэ? Гэх зэрэг асуултад сурагчийг үндэслэлтэй хариу өгүүлэх зорилгоор “Нийгмийн хариуцлага”-ын ангиллыг тодорхойлоход нь чиглүүлээрэй.

Байгууллага ашигт ажиллагаатай, мөн нийгмийн хариуцлагаа биелүүлснээр зах зээл дээр тогтвортой оршин тогтнох боломжоо бий болгож байдаг. Тогтвортой оршин тогтнохын нэг үзүүлэлт бол түүний хөгжил байдаг. Зах зээлийн өрсөлдөөнд тогтвортой хөгжлийг хангаж чадаж байгаа байгууллага тогтвортой оршин тогтнож чадахыг онцлоорой.

Арга зүй, зохион байгуулалтын хувьд:

Энэ сэдвийн арга зүй нь хэлэлцүүлэг, асуудал шийдвэрлэхэд туулгуурлан явагдана. Хэлэлцүүлэг хийхээс өмнө хэлэлцүүлэг хийх хэлбэр болон дүрмээ анги нийтээрээ тогтох хэрэгтэй. Тухайлбал:

- Нэг хүүхэд нэг үг
- Нэг баг дөрвөн санаа

Сурагчийг хичээлийн сэдэвт анхааруулах хэсэг.

Хичээлийн цаг эхлэхэд аль нэг сурагчаас урьдчилан бэлтгэсэн бизнесийн үйл ажиллагааны талаарх зургийг бусдад харагдахуйц газарт байрлуулахыг хүсээрэй. Сурагчид анхаарлаа хандуулах үед багш “Хичээлийн сэдвийн нэрийг хэлнэ”. Ингэснээр хичээлийн явцад сурагч анхаарлаа зөвхөн бизнесийн нийгмийн хариуцлага, ёс зүйн хүрээнд хандуулахнээ гэдгээ ойлгоно.

Дараа нь багш “Нийгмийн ухаан” хичээлээр үзсэн “Нийгмийн хариуцлага, ёс зүйн” ойлголтуудын 5-8 түлхүүр үгийг самбарт бичээрэй. Мөн самбарт харгалзуулан энэ сэдвийн түлхүүр үгийг бичээрэй. Энэ нь нийгмийн ухааны хичээлээр үзсэн ойлголтыг бизнесийн үйл ажиллагаатай уялдуулан ойлгоход сурагчдад тусална.

Сэдвийн үндсэн агуулга “Нийгмийн хариуцлага”

Алхам 1. Сургуульд хамгийн ойр байгаа худалдаа, үйлчилгээний байгууллагын нийгмийн хариуцлагын талаар ярилцаж тэмдэглэл хийгээрэй.

Асуудал	Дүгнэлт
Хугацаа хэтэрсэн бараа борлуулах нь хариуцлагатай хэрэг мөн үү?	Бүтээгдэхүүний хадгалах хугацаа нэг хоногийн дараа дуусна.
Өдөр тутмын үйл ажиллагааг хэн хянадаг вэ?	Нэг хоногийн дараа хугацаа дууссан тараг лангуун дээр хяналт тавих ёстой эзэн, худалдагч гэх мэт хүний хариуцлагагүй үйлдэл гэж үзнэ.
Нэг өдрийн дараа хугацаа дуусах тараг худалдан авч түүнээс хоёр хоногийн дараа задлан идэхэд муудсан байлаа. Хэний хариуцлагагүй үйлдэл гэж бодож байна вэ? Яагаад?	Хэрэглэгч хариуцлагагүй.

Багшийн оролцоо нь: Хичээлийн явцад асуудлыг илрүүлэхэд туслах Асуудлыг шийдвэрлэх зөвлөн чиглүүлээрэй.

Алхам 2. Чимээгүй уншилт

Зорилго: Нийгмийн хариуцлагаа биелүүлэхийн ач холбогдлыг ойлгох

Сурагчийн номны Хүснэгт 2.3.1. Уншиж дууссан сурагч алхам нэгд хийсэн хүснэгтээс харгалзах зүйлсийг хооронд нь холбож бичнэ.

Асуудал	Дүгнэлт	Үр нөлөө
Хугацаа хэтэрсэн бараа борлуулах нь ёс зүйтэй хэрэг мөн үү?	Хугацаа дуусаагүй байгаа. Нэг хоногийн дараа дуусна.	Бизнесийн байгууллага урт хугацаанд ашиг олох сонирхолтой байвал чанартай бүтээгдэхүүн худалдах нь байгууллагын тогтвортой оршин тогтнолд шууд нөлөлнө.
Өдөр тутмын үйл ажиллагааг	Нэг хоногийн дараагаар	Дэлгүүрийн ашиг олохоос гадна

хэн хянадаг вэ?	лангуун дээр байвал худалдаа нь дуусах бараа хяналт хийж байгаа хүний хариуцлагатай ярина.	нийгэмд сөрөг нөлөө үзүүлэхгүйгээр байхаар үйл ажиллагаагаа явуулахын тулд удахгүй хугацаа дуусах гэж байгаа барааг өөр нэг хэсэгт төвлөрүүлэн байршуулах хэрэгтэй.
Нэг өдрийн дараа хугацаа дуусах тараг худалдан авч түүнээс хоёр хоногийн дараа задлан идэхэд муудсан байлаа. Хэний хариуцлагагүй үйлдэл гэж бодож байна вэ? Яагаад?	Хэрэглэгч хариуцлагагүй.	Тараг худалдан авахаас өмнө хугацааг харах хэрэгтэй байсан.

- Алхам 3. Хэлэлцүүлэг
 А. Тарагны хугацаа нэг хоногийн дараа дуусахыг хэрхэн мэдэж болох вэ?
 Б. Хүнсний бүтээгдэхүүн дээрх дуусах хугацааны тэмдэглэл бүр адил байдаг уу?
 В. Бусад өргөн хэрэглээний барааны дуусах хугацааг хэрхэн тэмдэглэсэн байдаг вэ?

- Алхам 4. Ажиглалт
 Нийгмийн хариуцлага нь бизнес эрхлэгчийн үйл ажиллагаанд хэрхэн нөлөөлж болохыг сурагчийн номны 2.3.2 зураг харж тайлбарлан ярилцаарай.

- Алхам 5. Дүгнэлт хэсэг
 Нийгмийн хариуцлагаа ухамсарлах нь бизнес эрхлэгчид ямар ач холбогдолтой болохыг сурагчаар тодорхойлуулан бичүүлээрэй.
 (*Багш явцын үнэлгээг дэвтэр хураагаад дараа нь үнэлнэ.)

Сэдвийн үндсэн агуулга “Нийгмийн хариуцлагын төрөл”

- Алхам 1. Сурагч хичээлийн бэлтгэл болгон “Танилцах аялал”-ыг бие даан хийж, сэдэвтэй холбоотой бодит жишээ гаргаж болно. Тухайлбал, барааг зарж борлуулж байгаа ажилтан, үүрэг өгсөн удирдлага хоёрын ёс зүйн гажуудал нь байгууллагын үйл ажиллагаанд хэрхэн нөлөөлж байгааг жишээгээр тайлбарлах.
- Алхам 2. Танилцах аялал хийсэн байгууллагын явуулж байгаа үйл ажиллагаатай холбоотой нийгмийн хариуцлагын жишээг (3-4 жишээ) хүснэгтийг ашиглан гүйцэтгүүлээрэй. Даалгаварыг гүйцэтгэхийн тулд сурагч бага хэмжээний судалгаа хийнэ. Бизнес судлал хичээлийг хамгийн сайн сурах арга зүй бол бие даан судалгаа хийх байдаг. Өөрөөр хэлбэл, сурагч бие даан судалгаа хийх явцдаа дараах алхмуудыг логиктой хийж суралцдаг. Тодорхойлох, мэдээллийн эх сурвалжийг нээх, түүнээс өөрт хэрэгтэйг сонгох, цуглуулсан мэдээллээ боловсруулах, танилцуулах, үнэлэх.)

Асуудал	Дүгнэлт
	Хариуцлагатай/Хариуцлагагүй
	Хариуцлагатай/Хариуцлагагүй
	Хариуцлагатай/Хариуцлагагүй

- Алхам 3. Чимээгүй уншилт
 Зорилго: Бизнес эрхлэгчийн ашиг сонирхол, хандлага өөр байдгаас шалтгаалан тэд нийгмийн хариуцлагаа янз бүрийн байдлаар биелүүлдгийг ойлгож мэдэх.

Сурагчийн номны “Нийгмийн хариуцлагын төрөл” дэд сэдвийг унших. (Хичээлийн цаг ашиглалтыг бодолцон багш сурагчдад гэртээ бие даан унших даалгавар өгч болно.)

Уншилт хийлгэх явцад Бүдүүвч 2.3.1 болон 2.3.2-ийг сурагчдын мэдээлэл боловсруулах чадвар хөгжүүлэхэд ашиглаж болно. (Учир нь, энэ сэдвийн хүрээнд олон төрлийн тоон болон чанарын мэдээллийг боловсруулан, байгууллага нийгмийн хариуцлагатай үйл ажиллагаа явуулж байгаа эсэх болон ёс зүйтэй бизнесийн шийдвэрийг гаргасан эсэх дээр дүгнэлт хийснээр сурагчдын мэдээлэл боловсруулах чадвар хөгжихөд тусална.)

Алхам 4. Хэлэлцүүлэг

Бизнесийн нийгмийн хариуцлага хэнд хамаарах талаар бизнесийн үйл ажиллагааны чиглэлтэй нь холбож тодорхойлно. Жишээ нь, Гоо сайхны салоны эзний нийгмийн хариуцлага нь тус салоны ажилчид, байр түрээслэгч, түншүүд, үйлчлүүлэгчид зэрэг маш өргөн хүрээг хамарч нөлөө үзүүлдэг гэдгийг ойлгоно.

Алхам 5. Дүгнэлт

Бизнесийн үйл ажиллагаа өргөжин тэлэхийн хамт нийгмийн хариуцлага мөн нэмэгддэг гэдгийг сурагчаар тодорхойлуулан бичүүлээрэй (дэвтэрт).


Сэдвийн үндсэн агуулга “Бизнесийн ёс зүй”

Алхам 1. Чимээгүй уншилт

Зорилго: Бизнесийн ёс зүйн онолын ойлголтыг өгөх.

Алхам 2.

Багш дараах нэмэлт мэдээллийг ашиглан сурагчдад зөвлөж чиглүүлээрэй.



Алхам 3. Дүгнэлт

Бизнесийн үйл ажиллагааг ёс зүйтэй явуулах хэрэгтэй болох талаар сэдэвтэй холбоотой түлхүүр үгийг ашиглан зохион бичлэг бичих даалгаврыг сурагчдад өгөөрэй.

Үнэлгээний хувьд

Багш сурагчдыг сэдвийн хүрээнд зохих хэмжээний мэдлэгтэй болсон эсэхийг түлхүүр үг ашиглаж байгаагаар, чадварт суралцсаныг мэдээлэл боловсруулан хэрэглэж байгаагаар, харин хандлага төлөвшсөн эсэхийг нь даалгаврын гүйцэтгэлээр үнэлж болно.

Үнэлгээн ашиглах хуудас

	Хандлага	Мэдлэг	Чадвар		Нийт
			Нэмэлт мэдээллийн эх сурвалж ашигласан байдал	Боловсруулж	
	Гүйцэтгэсэн	Түлхүүр үг оновчтой ашигласан	Боловсруулаагүй шууд	Боловсруулж	
Оноо	40 хүртэл	20 хүртэл	10 хүртэл	30 хүртэл	100
1					
2					
3					
4					
5					

Бататгал хэсэгт байгаа 6 асуултыг үнэлэхдээ хариулт бүрийг яагаад буруу, яагаад зөв болохыг сурагчдад тайлбарлан ойлгуулаарай. Учир нь, сурагч бусад хариулт яагаад буруу болохыг олж мэдсэнээр яагаад зөв болохыг илүү сайн ойлгодог.

№	Хариу	Тайлбар
1	A	
	B	
	C 3ӨВ	
	D	
2		

Сурагч даалгавар, бататгалын асуулт бүрийг хийж гүйцэтгэснээр дараах суралцахуйн зорилтод хүрсэн байна. Дараах хүснэгтийг сурагч өөрийн үнэлгээний нэг хэрэглэгдэхүүн болгон ашиглах боломжтой.

	Даалгавар					Бие даалт					
	1	2	3	4	5	1	2	3	4	5	6
Бизнес эрхлэгч хувь хүн, байгууллагын удирдах албан тушаалтан бизнесийн ёс зүйг баримталж байгаа эсэхийг тодорхойлж сурна		√	√	√	√			√		√	√
Бизнесийн байгууллагын үйл ажиллагаа хэм хэмжээ, ёс зүйн хүрээнд явагдаж байгаа эсэхийг тодорхойлж сурна			√	√	√			√		√	
Нийгмийн хариуцлагын ойлгож мэднэ	√	√	√	√	√	√		√	√		
Нийгмийн хариуцлага ба бизнесийн үйл ажиллагааны уялдаа холбоог ойлгож мэднэ											
Бизнесийн байгууллага үйл ажиллагаа явуулахдаа ёс зүйн зарчмыг баримтлах нь ямар ач холбогдолтойг ойлгож мэднэ	√	√	√	√	√			√	√	√	
Бизнесийн байгууллага нийгмийн хариуцлагаа бүрэн ухамсарласан эсэхийг тодорхойлж сурна		√	√	√				√		√	

Сурах бичгийн даалгавар гүйцэтгэл, асуултын хариу

Даалгавар 1.

Ашиглах түлхүүр үг:

Нийгмийн хариуцлага
 Бизнесийн үйл ажиллагааны чиглэл
 Бизнесийн байгууллагын үнэт зүйл, зарчим
 Бизнесийн түншийн эрх ашгийг хүндэтгэх
 Бизнесийн байгууллагын удирдах ажилтаны хувийн зан чанар
 Бизнесийн байгууллагын ажилтаны зан чанар, хандлага
 Нийгэм, эдийн засаг, байгаль орчинд үзүүлэх эерэг, сөрөг нөлөө
 Харилцагчдад хандах хандлага

Гүйцэтгэх зөвлөмж:

Сурагч зохион бичлэг бичихдээ тухайн сонгосон байгууллага үйл ажиллагаандаа нийгмийн хариуцлагаа хэрхэн биелүүлж байгааг тодорхойлж бичнэ. Мөн тухайн байгууллагын ажилтны үйл ажиллагаа нь ёс зүйтэй, хариуцлагтай байгаа эсэхийг бичнэ.

Даалгавар 2.

Ашиглах түлхүүр үг:

Даалгавар нэгийн түлхүүр үгс
 Бизнесийн ёс зүй, үйл ажиллагаа

Бизнесийн орчин
 Гүйцэтгэх зөвлөмж: Энэ даалгаварыг сурагчид багаар гүйцэтгэнэ. Багууд өгсөн мэдээллийн хүрээнд нийгмийн хариуцлагын тухай асуудлыг багаар хэлэлцэж, өөр гаргалгаа юу болох талаарх үндэслэлээ тайлбарлаарай.

Ийм төрлийн даалгаварыг үнэлхдээ тухайн сурагч нь нийгмийн хариуцлага ба ёс зүйн талаар хангалттай ойлголт авсан эсэх, түлхүүр үг оновчтой хэрэглэж чадаж байгаа эсэхэд анхаарал хандуулаарай.

Даалгавар 3.4

Ашиглах түлхүүр үг:
 Гүйцэтгэх зөвлөмж:

Даалгавар хоёрын түлхүүр үгс: Бизнесийн ёс зүй

3,4 дүгээр даалгаварыг гүйцэтгэхдээ багаар ажиллах нь илүү тохиромжтой. Даалгаварын гол зорилго нь амьдралд тулгар ч буй тогтвортой хөгжлийн асуудлыг илрүүлэх. Илрүүлсэн асуудлыг шийдвэрлэхэд сурагч хэрхэн оролцож болох талаар санал дэвшүүлсэн байх хэрэгтэй.

Даалгавар 5.

Ашиглах түлхүүр үг:

Даалгавар хоёрын түлхүүр үгс

Гүйцэтгэх зөвлөмж:

Ёс зүй, соёл нь мөнгөний зарцуулалт, хуримтлал болон тогтвортой хөгжилд гаргаж байгаа санхүүгийн шийдвэрүүдэд хэрхэн нөлөөлдөг болох талаар багаараа хэлэлцэх, бусаддаа тайлбарлах. Багууд хоорондоо санал, бодлоо солилцож, нийтлэг саналыг нэгтгэн ярилцаж дүгнэлтэд хүрнэ.

Өөрийгөө сориорой

№	Хариу	Тайлбар
1	A	
	B	
	C	ЗӨВ
	D	
2	A	Нийгмийн бүх асуудлууд
	B	Нийгмийн зарим асуудлууд
	C	Нийгмийн асуудал биш
	D	Эдийн засгийн бүх асуудал
3	A	
	B	
	C	
	D	
	E	
4	A	
	B	
	C	
	D	
5	A	
	B	
	C	
	D	